



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/160

Улаанбаатар хот

“Ойн төгөл”-д мод, сөөг, зүлэг тарих,
арчлах хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3 дугаар бүлгийн 3.38, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын орон сууцны хороолол дотор байгуулах “Ойн төгөл”-д мод, сөөг, зүлэг тарих, арчлах ажлын зардал, гүйцэтгэгч байгууллагуудыг хавсралт ёсоор баталсугай.

2. “Ойн төгөл”-д мод, сөөг, зүлэг тарих, арчлах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээ байгуулж, тарилт, арчлалтын ажлын явц, биелэлт, агротехнологийн горимын мөрдөлтөнд Төрийн бус байгууллагатай хамтран хяналт тавьж, мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/- т даалгасугай.

3. Мод, сөөг, зүлэг тарих, арчлах ажилд шаардагдах нийт 280.158.320 /Хоёр зуун наян сая нэг зуун тавин найман мянга гурван зуун хорин/ төгрөгийг ногоон байгууламжийн арчилгааны зардлаас гарган, гүйцэтгэлээр санхүүжүүлж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/ -д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны *свэгнэлт* сарын *01* өдрийн
А.Н.Б.Д.У.М.Т.Ш.А.Л. хушаалын хавсралт

“ОЙН ТӨГӨЛ”-Д МОД, СӨӨГ, ЗҮЛЭГ ТАРИХ ЗАРДАЛ,
 ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГУУД

Д.Д	Байршил	Төсөв /төгрөг/	Гүйцэтгэх байгууллага
	Нэг. Чингэлтэй дүүрэг		
1.	38,21-р байрны дунд	5.757.475	Хорсбэк экспэрэнс ХХК
2.	21-р байрны өмнө /зүлэг -675м2/	10.000.000	Хас төгөл ХХК
3.	2-р 40 мянгат 29-р байр, 50 мянгат 19-р байр	5.714.315	Бага хаян ХХК
	Хоёр. Сүхбаатар дүүрэг		
1.	Хөгжим бүжгийн коллеж, 4-р байрны өмнө	7.586.320	Мөнх ногоон шугуй ХХК
2.	44-р байрны зүүн талд	5.012.390	ММБ ландшафт ХХК
3.	20-р байр /мод, зүлэг- 610м2/	10.000.000	Ботгон хоолой ХХК
4.	43,52-р байрны дунд	6.865.810	Арвин билэг сайхан ХХК
5.	Дамбадаржаалин хийд /1-р хэсэг/	8.000.000	Алсын эрдэнэ ХХК
6.	Дамбадаржаалин хийд /2-р хэсэг/	8.933.750	Түмэн ганга ХХК
	Гурав. Баянгол дүүрэг		
1.	2а,2б,2в байрны хойд тал, 13-р хорооны байр	10.000.000	Ай Эм Ди ХХК
2.	21,22-р байрны дунд	10.000.000	НБНМДД ХХК
3.	21,22-р байрны дунд /зүлэг-700м2	10.000.000	И эйч эс эм ХХК
4.	21,22-р байрны дунд /зүлэг-700м2	10.000.000	Грийт роял сити ХХК
5.	35-р байрны урд, 22-р бага сургуулийн хойно	9.439.740	Энх болор байгаль ХХК
6.	45,46-р байрны хойно /мод, зүлэг-450м2/	10.000.000	Байгаль үндэс ХХК
	Дөрөв. Хан-уул дүүрэг		
1.	39,42-р байрны урд /мод, зүлэг-170м2/	7.830.330	Мөнх ногоон мод ХХК
2.	20,30-р байрны урд /мод, зүлэг- 200м2/	10.000.000	Сэрүүн хангай ХХК
3.	19-р байр /мод, зүлэг-300м2/	10.000.000	Зэмэст ХХК
	Тав. Баянзүрх дүүрэг		
1.	17,17а байрны дунд /зүлэг -270м2/	6.488.460	Ашид адист очир ХХК
2.	5, 53-р байрны хойд тал	10.000.000	Гүн бүрд нуур ХХК
3.	55-р байрны хойно /агч 150ш/	9.890.000	Жиллион ланд ХХК
4.	55-р байрны хойно /улиас-100ш/	7.100.000	Агч ногоон ой ХХК
5.	10-р байрны ард /мод,зүлэг-465м2/	10.000.000	Аатай ХХК
6.	Ахмадын хороолол	10.000.000	Нью грийн форест ХХК
7.	15-р байрны ард /мод/	9.008.755	Тэтгэгч хур ХХК
8.	15-р байрны ард /зүлэг-1025м2/	10.000.000	Цагаан уул төгөл ХХК
	Зургаа. Сонгинохайрхан дүүрэг		
1.	14-р байрны баруун тал /зүлэг-350м2/	10.000.000	ХИКС ХХК
2.	24-р байрны урд /зүлэг- 300м2/	10.000.000	Зэмбэ хайрхан ХХК
3.	33-р байр	5.418.800	Мон плант гарден ХХК
4.	136,11-р байрны дунд /зүлэг-320м2/	10.000.000	Сайн тохижилт ХХК
5.	1,2,3,60-р байрны дунд /мод,сөөг/	7.112.175	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төв ТББ
6.	1,2,3,60-р байрны дунд /зүлэг-800м2/	10.000.000	Монголын фермер эмэгтэйчүүдийн холбоо ХХК
	ДҮН /төгрөг/	280.158.320	